



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОО-2020/8/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	11





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.13 № 276

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрэнцэв хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрэнцэв хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрэнцэв хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520198



Үүрэг, хариуцлага

Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Нэргүй танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан байгууллага айл өрхийн хог ачилт болон цэвэрлэгээг тогтмол хийх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд 7 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 67,092. мянган төгрөгөөс тооцон 1,341.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,162.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,849.3 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, өр төлбөр, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,718.5	2,163.6	-5,554.9
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	435.0	2,935.0	2,500.0
Үндсэн хөрөнгө	693,131.5	693,131.5	0,0
Элэгдэл	-218,871.3	-266,665.7	-47,794.4
Нийт хөрөнгө	492,501.7	441,652.4	-50,849.3
Өр төлбөр	4,400.0		-4,400.0
Хуримтлагдсан ашиг	-42,892.1	-46,449.3	-3,557.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	201,915.6	201,915.6	0,0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	492,501.7	441,652.4	-50,849.3

Авлага дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,500.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь хогны машинд сэлбэг хэрэгсэл авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,400.0 мянган төгрөгөөр буурсан нь төлбөрийн актны төлбөрийг төлсөнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 46,449.3 мянган төгрөг болж 3,557.2 мянган төгрөгөөр буурсан байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Эрэнцав хөгжил ОНӨААТҮГ нь нийт 11,700.0 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 8,200.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, түрээсийн орлогын 3,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, “Хог хөтөлбөрт 8,168.5 мянган төгрөг, гэрэл цахилгаанд 177.7 мянган төгрөг, бараа материал худалдан авахад 3,100.0 мянган төгрөг, түлш шатахуунд 1,000.0 мянган төгрөг, актны төлбөр 4,400.0 мянган төгрөг, бусад зардалд 408.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.



2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар 9,520.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллаагүй зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн 9,520.5 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллахад анхаарах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдан зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн төлөвлөгөөний талаар

1.1. Илрүүлэлт: Тайлант онд Эрээнцав хөгжил ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа алдагдах. Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Төлөвлөгөө батлуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8153566,90	5098611,90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7718566,90	2163611,90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7718566,90	2163611,90
3121	Төгрөг	7718566,90	2163611,90
31213	Арилжааны банк дахь харилцах	7718566,90	2163611,90
35	БАРАА МАТЕРИАЛ	435000,00	2935000,00
354	Хангамжийн материал	435000,00	2935000,00
35420	Аж ахуйн материал	435000,00	2935000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	484348216,83	436553793,18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	484348216,83	436553793,18
392	Биет хөрөнгө	474260216,83	426465793,18
39201	Барилга, байгууламж, орон сууц	242435144,72	242435144,72
39202	Хуримтлагдсан элэгдэл		9867636,22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	105100000,00	105100000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	68067000,39	79860714,43
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	445000,00	445000,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	378250,17	445000,00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	590000,00	590000,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	250749,66	309749,58
39214	Бусад үндсэн хөрөнгө	344561359,00	344561359,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	150175286,67	176182610,31
393	Биет бус хөрөнгө	10088000,00	10088000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	10088000,00	10088000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	492501783,73	441652405,08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	488101783,73	441652405,08
51	Засгийн газрын хувь оролцоо	488101783,73	441652405,08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10088000,00	10088000,00
512	Хуримтлагдсан үр дүн	276098175,57	229648796,92
51210	Өмнөх үеийн үр дүн	318990235,33	276098175,57
51220	Тайлант үеийн үр дүн	-42892059,76	-46449378,65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201915608,16	201915608,16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	492501783,73	441652405,08

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	24200000,00	11700000,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24200000,00	11700000,00
120	Нийтлэг татварын бус орлого	24200000,00	11700000,00
120009	Бусад орлого	24200000,00	11700000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	67092059,76	58149378,65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67092059,76	58149378,65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67092059,76	58149378,65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66845551,76	58149378,65



210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22554500,00	10354955,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44291051,76	47794423,65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-42892059,76	-46449378,65
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-42892059,76	-46449378,65
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-42892059,76	-46449378,65

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	28600000,00	11700000,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28600000,00	11700000,00
120	Нийтлэг татварын бус орлого	28600000,00	11700000,00
120009	Бусад орлого	28600000,00	11700000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	22801008,00	17254955,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22801008,00	17254955,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22801008,00	17254955,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22554500,00	17254955,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22554500,00	17254955,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5798992,00	-5554955,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5798992,00	-5554955,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1919574,90	7718566,90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7718566,90	2163611,90

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10 088 000,00	201 915 608,16	276 098 175,57		488 101 783,73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0,00		0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10 088 000,00	201 915 608,16	276 098 175,57	0,00	488 101 783,73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
C07	Тайлант үеийн үр дүн					0,00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10 088 000,00	201 915 608,16	276 098 175,57	0,00	488 101 783,73
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10 088 000,00	201 915 608,16	276 098 175,57	0,00	488 101 783,73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10 088 000,00	201 915 608,16	276 098 175,57	0,00	488 101 783,73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00



Эрэнцэв хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-46 449 378,65		-46 449 378,65
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10 088 000,00	201 915 608,16	229 648 796,92	0,00	441 652 405,08